



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/145

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлж хугацаат цэргийн албанд татагдан алба хааж байгаа дайчдын албан үүргээ гүйцэтгэх, ая тухтай амьдах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс хувийн эд зүйл хадгалах төмөр шкаф худалдан авах зардалд 3,030,000 (гурван сая гучин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 3,030,000 (гурван сая гучин мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын эрх зүй, нийгмийн хэв журам хөтөлбөрт тусгагдсан Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

